

МАРГААШИЙН БАГШ БАЙХЫН ТУЛД

Чинбатын ДОЛГОРЖАВ

Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Математик Байгалийн Ухааны Сургууль,
Мэдээлэл зүйн тэнхим

Abstract

Adaptability is one of basic skills of human beings for becoming socialized. The way of being adaptable is responding to the environment by solving issues between undersense and external circumstances. Thus, the important thing for socially living is to respond effectively to the challenges and take a new advatanges. We meet a lot of social demand day by day, due to living in the era driven by technological development. In IT based society, our daily lifestyle is surrounded by intelligent devices and plenty of resource. Parent-child and teacher-child conflicts becoming a big issue in the current society due to prohibiting kids' overuse of electronic devices, Facebook and Internet. Instead of restriction, we have to find out opportunities which created by usage of social media and lead them to a proper usage in order to prevent conflicts. In this study we consider about taking advantage of students' usage of social media into class activities; preventing them from improper usage of Internet through their interest on social media usage.

Түлхүүр үг: Фэйсбүүкийн хэрэглээ, ирээдүйн багш, технологийн дэвшил

I. Удиртгал

Боловсролтой, өндөр ур чадвартай хүний нөөц нь улс орны хөгжлийн түлхүүр байсаар ирсэн бөгөөд түүний нэгэн гол хүчин зүйл нь бүх шатны боловсролын байгууллагын багшлах боловсон хүчин юм. Ахмад үеийн багш нарт хийхгүй ажил байгаагүй гэж яруу найрагт¹ гардагчлан, ЕБС-ийн шилдэг төгсөгчдөөс багш мэргэжлийг сонгож эзэмшдэг хүн олон байсан үе саяхан. Монгол улс зах зээлийн нийгэмд шилжсэнээс хойш энэ байдал өөрчлөгдөж, бизнес, банк, санхүү, худалдаа зэрэг мэргэжил рүү элсэгчид хошууран, өнөөдөр их дээд сургуулиудын 80%-ийг эзэлсэн дээрх чиглэлийн олон тооны хувийн сургуулиуд бий болоод байна (*Дэлхийн банкны тайлан, 2011*).

Нийгэм дэх багш мэргэжлийн үнэлэмж, ажлын ачаалал, цалин хөлс зэргээс шалтгаалан, ЕБС-ийн шилдэг төгсөгчид багш

Өчигдрийн аргаар

Өнөөдрийн ажлыг хийж

Маргааш амжилт олно гэж үгүй

бэлтгэх сургуулиудад элсдэггүй² үзэгдэл нийгэмд хэвшиж. Энэ байдал хэвээр үргэлжилбэл улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн чухал хөдөлгөгч хүч болсон боловсрол эргэлт буцалтгүйгээр унах аюул ойрхон мэт. Бид нэгэнт өнгөрснийг буцааж чадахгүйн учир маргаашийн болзошгүй ирээдүйг зөв таамаглаж, урьдчилж арга хэмжээ авах замаар маргаашаасаа эерэг үр дүн хүлээх гарцыг байнга эрэлхийлж, өнөөдрийн болон ирээдүйн багш нарын хандлагад бидний зүгээс орхигдуулж байгаа тал байвал цаг алдалгүй засах ёстой.

МАРГААШ ЯМАР БАЙХ ВЭ?

Өнөөгийн нийгмийн өөрчлөлтөд хамгийн тод ажиглагдаж байгаа, цаашид ч хүчтэй өөрчлөгдөх нь i) Техник, технологийн хөгжил дэвшил бүхнийг жолоодох байдал, ii) Монгол улсын хувьд шилжилтийн үеийг даван туулж,

¹"Багш" найраглалын хэсгээс. Ардын уран зохиолч Ш.Сүрэнжав

² 2014-2015 оны элсэлтийн дүнгээр МУИС-ийн элсэгчдийн дундаж 648, МУБИС-ийн дундаж оноо 614 гэж тэмдэглэгдсэн байна.

зах зээлийн нийгэмд бүрэн шилжин орох нөхцөл, iii) үр дүнд нь хөдөлмөрийн болон аль ч зах зээлд өрсөлдөөн илүү хүчтэй явагдах хандлагуудыг дурдаж болохоор байна.

Эндээс харвал **технологи, өрсөлдөөн** гэдэг хоёр хүчтэй тоглогч маргааш ч нийгэмд эзлэх байр сууриа алдахгүй хэвээр байх нь. Мэдээлэл, технологийн эринд хэн хамгийн хурдан мэдээллийг олж авна|түгээнэ, тэр хэрээрээ зах зээлийн үндсэн зарчим болох өрсөлдөөнд давуу байж, ингэснээр тухайн хүний амьдрах чадвар, амьдралын чанар дээшилнэ. Мэдээлэл нь өөрөө эзэмшиж байгаа хүнд давуу тал олгодог хэдий ч удаан хадгалах тусам үнэ цэнэ нь буурдаг капитал юм.

Тиймээс асар хурдан өөрчлөгдөж байгаа хөгжил дэвшилд дасан зохицож чадах, технологийн дэвшлээс тухай бүрд давуу талыг нь ашиглан, эерэг үр нөлөө гаргаж чаддаг багшийг бэлтгэхэд багш боловсролын байгууллагууд анхаарлаа хандуулах ёстой болоод байна.

Интернэтэд байршсан мэдээ, мэдээллийн хэрэглээ нэмэгдэхийн хэрээр олон нийтийн сүлжээг ашиглах хандлага нэмэгддэг нийгмийн аль ч шатанд мэдээлэл түгээх Вэб 2.0 технологи (блог, твиттер, вики сайтууд, олон нийтийн сүлжээ, виртуал ертөнц, видео болон фото бусдад түгээх) руу хүмүүс асар хүчтэй татагдан орсоор байгаа бөгөөд оюутнуудын хувьд ч Интернэт нь тэдний нийгмийн болон академик амьдралд гол нөлөө үзүүлж байна (Caroline, Towne., 2009). Гэтэл тэдгээр хүүхэдтэй ажиллаж байгаа багш нар өчигдрийн номтой ажиллаж сурсан тэр нөхцөлөө оюутнаас, хүүхдээс шаардах нь бидний анзаарахгүй орхидог байж болох зөрчлийг үүсгэж байна уу? Аливаа нийгэмд хүн гадаад орчны нөлөө, дотоод мэдрэмжийн зөрчлийг сааруулж, хариу үйлдэл үзүүлэх замаар дасан зохицож амьдардаг. Хүүхдийг Фэйсбүүк ашиглахыг нь хорих, хязгаарлах нь биднээс ном ашиглахгүй байхыг шаардвал ямар утгагүй сонсогдохтой л адил байж болох бус уу? Иймд тэдний сонирхолд тулгуурлан, хүссэн чиг рүүгээ зүглүүлж болох уу?

Бид энэхүү таамгаа батлахын тулд багш суралцагчдын харьцаа, насны бүтэц, тэдний хооронд интернэт болон Фэйсбүүк хэрэглээнээс үүдсэн зөрчил бий эсэх, оюутны сурах орчин зэрэгт тоон болон чанарын

судалгааны аргаар мэдээлэл цуглуулж, шаардлагатай баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж үзлээ. Асуулгаар авсан судалгаанд МУБИС-ийн 237 оюутан, туршилтын судалгаанд өөр өөр мэргэжлийн 10 хүн хамрагдав.

II. Мэдээллийн Технологи – Боловсрол

Өнөөгийн даяаршиж байгаа нийгэмд технологи бол өрсөлдөөний, өсөж хөгжихийн гол түлхүүр, боловсролыг хүргэх суурь хэрэглүүр, цаашлаад улс орны хөгжлийн чиг хандлага болоод байна. Боловсролыг хүргэх үйлчилгээнд технологи ашиглан зардлыг бууруулснаар улс орны эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлнэ. Ингэснээр шууд утгаараа нэмүү өртөг шингэсэн бус, мэдлэг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь мэдлэгт суурилсан эдийн засгийн бодит өсөлтийг бий болгох чухал түлхэц болно. (Зураг 1).

Өнөөдрийн тухай өчигдрийн таамаг

Цахим ертөнц бидний амьдралын салшгүй хэсэг төдийгүй, ирээдүйд боловсрол олгох гол түлхүүр бол компьютер, электрон төхөөрөмжтэй холбоотой зүйлс байх болно гэдгийг эрдэмтэд хэдийнээс таамагласаар ирсэн бөгөөд энэ нь жил ирэх тусам батлагдсаар байна. EDUCAUSE³, CHEMA⁴ байгууллагуудын судалгаагаар дээд боловсролд хамгийн их өөрчлөлт авчрах 2 дахь хүчин зүйл⁵ бол технологийн өөрчлөлт хэмээн үнэлжээ (Philip, 2006). Интернэт бий болсноор улс орон, шашин шүтлэг, нас хүйс, арьсны өнгө хамаарахгүйгээр чөлөөтэй сурч, боловсрох эрхийг хүн төрөлхтөнд өгсөн бөгөөд 1997 онд Форбес⁶ сэтгүүлд “30 жилийн дараа гэхэд их сургуулиудын кампус үгүй болно. Энэ бол анх хэвлэмэл ном үзэж байсантай дүйхүйц том өөрчлөлт юм” хэмээн хэлсэн Питер Дракерийн таамагласан нь, Майкрософт компанийн тэргүүн Билл Гейтсийн 2010 онд “Ердөө таван жилийн дараа гэхэд дэлхийн шилдэг лекцүүдийг интернэтээс олдог болно” хэмээн хэлсэн нь

³ МТ-ийн хэрэглээгээр дамжуулан дээд боловсролыг хөгжүүлэх зорилго бүхий ашигийн бус байгууллага. АНУ

⁴ Менежментэд чиглэсэн дээд боловсролын АНУ, Канадын холбоодын албан бус, сайн дурын ассамблей. (<http://www.chemaorg.net>)

⁵ Анхдагч хүчин зүйл бол санхүүгийн эх сурвалж гэж үзжээ.

⁶ Санхүү, бизнес, үйлдвэрлэл, технологи, ШУ-ны чиглэлээр нийтэлдэг АНУ-ын нэр хүнд бүхий сэтгүүл

түвшнээс дээгүүр, өмнө жилийнхээсээ өсөлттэй байна (График 1).




График 1. Монгол улсын технологийн хөгжлийн харьцуулалт. 2013 оны тайлангаас нэгтгэв.

- Дэлхийн банкны мэдээгээр¹³ Монгол улсын интернэт хэрэглэгчийн тоо тогтмол өсөлттэй байна. Мөн үүрэн телефоны болон интернэт хэрэглэгчийн тоо, үүнийг дагасан өгөгдлийн урсгал сүүлийн жилүүдэд тогтмол өсөлт ажиглагдаж байгааг “Цагаан ном-2014”¹⁴-д тэмдэглэжээ.

Ш. Гогцоо

Нэгэнт технологийн хэрэглээ үүлэн тооцоолол болон хөдөлгөөнт хэрэгсэлд суурилах чиг хандлага руу тэмүүлж байхад сурах-сургах үйл ажиллагаа мөн BYOD¹⁵ руу чиглэнэ гэж таамаглах нь гарцаагүй юм. BYOD өөрөө “*хичээл, сургалтын процесст суралцагч өөрийн төхөөрөмжөөр хандах, мэдээлэл авах*” гэж тайлбарлагддаг байна (en.wikipedia.org).

Өнөөдөр дэлхий дээр мэдээллийг хамгийн хурдан түгээгч хэрэгсэл бол олон нийтийн цахим сүлжээ, тэр дундаа Фэйсбүүк сүлжээ тэргүүлэгч болоод байна. Хүмүүс зурагт, радио, сониноос илүү цахим сүлжээнээс мэдээлэл авах байдал давамгайлсан учир CNN, BBC г.м дэлхийн мэдээллийн томоохон агентлагууд бүгд олон нийтийн цахим сүлжээгээр мэдээллийг үндсэн сувгуудаасаа ч урьдчилан түгээж байна.

¹³ <http://data.worldbank.org> олон улсын хөгжлийн үндсэн үзүүлэлтийн бүх төрлийн өгөгдөл

¹⁴ Монгол улсын Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын “Цагаан ном-2014”. Энэ номонд олон нийтийн сүлжээнүүдээс манай орны иргэд хамгийн ихээр Фэйсбүүкийг хэрэглэдэг тухай мэдээлсэн байна.

¹⁵ Bring Your Own Device - “Хүмүүс ажлын байрандаа өөрийн төхөөрөмжөөсөө (гар утас, таблет, лаптоп) зөвшөөрөгдсөн мэдээлэл, програм руу хандахыг зөвшөөрөх” бодлого. (Wikipedia.org) 2009 оноос олон нийтэд түгээмэл нэр томъёо болж эхэлсэн.

Манай орны хувьд 2010 онд ердөө 161,6 мянган хэрэглэгчтэй байсан бол хамгийн сүүлийн дүн мэдээгээр Монгол улсын хүн амын 29,56% буюу 940 мянган хэрэглэгч Фэйсбүүкт бүртгэлтэй байгаагийн дотор 18-24 насны иргэд зонхилж байна (<http://analytics.socialdaily.com>, <http://socialbakers.com>). Энэ нь манай улсын их дээд сургууль, техник мэргэжлийн сургуулиудын оюутнуудын насны голлох бүтэцтэй давхцаж байгаа юм (БШУЯ-ны статистик). 25 хүртэлх насны оюутны тоо нийт оюутны 83,4% эзэлж байна (График 2а).

Гэтэл Монгол улсын бүх ЕБС болон их дээд сургуулийн багш нарын насны бүтцийг харахад 2014-2015 оны хичээлийн жилд ажиллаж байгаа ЕБС-ийн багш нарын 70%; их дээд сургуульд ажиллаж байгаа үндсэн багш нарын 75% нь 30 болон түүнээс дээш насны бүлэгт хамрагдаж байна (БШУЯ-ны тайлан, 2014), (График 2б).




График 2а. Их дээд сургуулийн бакалаврын түвшний оюутнуудын насны бүтэц.

Өөрөөр хэлбэл технологийн үсрэнгүй дэвшил гарч ирсэн үеэс өмнө сурч боловсорсон; сургалтын болон мэдээлэл авах үндсэн хэрэгсэл нь ном, сурах бичиг байсан тэр үед багш мэргэжил эзэмшсэн хүмүүс дийлэнх нь байна. Тэгэхээр оюутнууд байнга Фэйсбүүк хэрэглэдэг; харин багш нарын ихэнх, оюутны дийлэнх олонхын насны бүтэц огтлолцохгүй байгаад асуудал байгаа юм биш биз?¹⁶

Нэгэнт тэдний өдөр тутмын хэрэглээ болсон Фэйсбүүкийг нь хорихоос илүүтэй зөв хэрэглээг хэвшүүлснээр суралцагчдын үр ашиггүй зарцуулж байгаа цагийг бууруулж, үр дүнтэй, хяналттай болгох, олон нийтийн цахим хэрэгслийг аюулгүй ашиглах, өөрийгөө хянаж сурах, багш суралцагчийн үл

¹⁶ 30-11=19 (Зох)

ойлголцоос зайлсхийх, тэдний идэвхийг нэмэгдүүлэх г.м үр ашиг гарч болох юм. Судалгаагаар, технологи хэрэглэх төлөвшлийг эхнээс нь зөв дадаж заншвал цаашдаа буруу хэрэглээнээс татгалзаж чаддаг болох, замбараагүй олон асуудлуудын дунд төөрөхгүй зөв дадалтай болдгийг судалгаа харуулжээ (Andrew, 2007). Иймд өнөөгийн суралцагчидтай ажиллахдаа, маргаашийн хүүхэдтэй ажиллах багшийг бэлтгэхдээ энэ асуудлыг зайлшгүй авч үзэх нь зүйтэй болов уу.

Танхимд Фэйсбүүк, олон нийтийн сүлжээ ашигласнаар гарах ач холбогдол, үр дүнгийн талаар олон судалгаануудад дурдсан байна. Оюутнуудын дийлэнх нь Фэйсбүүк хэрэглэдэг тухай (Cheung et al, 2010; Hew, 2011; Mazman, Usluel 2010; Roblyer et al., 2010); оюутны сонирхолд тулгуурлан заах шинэлэг арга бол Фэйсбүүк гэдгийг (Hew, 2011); оюутныг харилцааны хамтрагч хэлбэрээр хүлээж авах нь энэ харилцааны тулгуур болох (Schwartz, 2009); үр нөлөөтэй арга зүйн ажил хийхийн тулд мэдлэг чадварыг хөгжүүлэх (Hew, 2011) г.м олон талаас нь авч үзжээ.

O'Sullivan, Hunt, Lippert (2008) болон Mazer, Murphy, Simonds (2009) нарын судалгаа Фэйсбүүкийг танхимд ашигласнаар суралцагч-суралцагч болон багш-суралцагчийн харилцааг маш сайн шатанд гаргадгийг илрүүлсэн байна. Гэхдээ сурагчтайгаа харилцаж байгаа гэдгээ огтхон ч марталгүй, болгоомжтой байх талаар Teclehaimanot, Nickman (2009) нар сануулжээ.

Гэвч олон хүний хувьд Фэйсбүүкийг хичээл, сургалтад, танхимд ашиглах гэдэгтэй санал нийлэхгүй байж болох юм. Учир нь цахим гэмт хэрэг, далд хүний наймаа, садар самууныг сурталчилсан агуулгууд ямар ч хяналтгүйгээр орж байдаг, мөн Фэйсбүүк, интернэтэд донтох үзэгдэл дэлхий даяар түгээмэл болж, эрүүл мэнд амь насаараа хохирох явдал ч гарсаар байгаа билээ. Ютагийн ИС-ийн судалгаагаар коллежийн оюутнууд Фэйсбүүкт зарцуулах цаг нь хэт ихсэх тусам амьдралдаа алдаа гаргаж байна гэж дүгнэжээ (Sachs, Wendy., 2012).

Чухамхүү ийм учраас, харин ч бид сонирхлыг нь хорих бус, зөв чиглүүлбэл дээрх асуудлуудыг тойрон гарахад нь тэдэнд туслах болно.




График 26. Монгол улсын хэмжээнд ажиллаж байгаа багш нарын насны бүтэц, 2014-2015 оны хичээлийн жилийн байдлаар

Бид манай орчинд оюутнуудын хувьд Фэйсбүүк хэрэглээний хугацаа, давтамж нь хэр байгааг тодруулах; хүмүүсийн өөрсдийн баримжаагаар тодорхойлж байгаа хэрэглээний хугацаа бодит байдалтай хэр нийцтэй болохыг харахаар 2 бичил судалгаа хийж үзлээ.

1) Бид оюутнуудын хувьд Фэйсбүүк хэрэглээ хэр байгааг харах асуулгыг МУБИС-ийн 237 оюутнаас авч үзэхэд тэдний бараг тэн хагас нь буюу 111 хүн өдөрт 2-5 цагийг зарцуулж байна. Мөн судалгаанд хамрагдагчдын дийлэнх хувь нь Фэйсбүүкийн хэрэглээнээс үүдсэн багш болон эцэг эхтэйгээ үүсгэх зөрчил ямар нэг хэмжээгээр гардаг гэж хариулснаас харахад оюутнууд хэт их цагийг Фэйсбүүкт зарцуулдаг, үүнээс улбаатай зөрчлүүд байсаар байна гэсэн бидний таамаг батлагдаж байна.

2) Хуульч, багш, мэдээллийн технологийн мэргэжилтэн, эмч зэрэг мэргэжилтэй 30-аас дээш насны 10 хүнээс Фэйсбүүкийн хэрэглээгээ хянаж чадаж байгаа эсэхийг нь баталгаажуулах судалгаа хийж үзлээ. Ингэхдээ тэдний өөрсдийн баримжааг бодит хугацаатай нь харьцуулсан бөгөөд бодит тоог онлайн тооцоолуур¹⁷ ашиглаж олсон болно. Гэтэл Фэйсбүүкийн өндөр хэрэглээтэй хүний хувьд тэдний өөрсдийн баримжаа тоо, бодит тоо 2 хол зөрүүтэй байгаа нь ажиглагдлаа. Өдөрт дунджаар 4-5 цаг орчим хугацааг Фэйсбүүкт зарцуулдаг гэж хариулсан хүмүүсийн хувьд тооцоолуураар гарсан дүн 8-9 цаг байна (Хүснэгт 1).

Үүнээс харахад, насанд хүрэгчид өөрсдөө ч Фэйсбүүкт хяналтгүй их цагийг зарцуулдаг, хэдэн цаг уяатай байгаагаа мэдрэхгүй байна. Иймээс, хүүхдүүд илүү их цагаар Фэйсбүүкт

¹⁷ Facebook time machine - <http://time.com/6107/time-wasted-on-facebook/>

уягдаж, түүнээс хэт хамааралтай болох магадлалтай байна.

Иймээс суралцагч чинь Фэйсбүүкт онлайн байгаа л бол заавал өөр хэрэгсэл рүү анхаарлыг нь хандуулахгүйгээр хаалттай болон сонирхлын бүлгүүд, санал асуулга,

хэрэгцээт программууд гээд давуу талуудыг ашиглан хэрэгтэй зүйлээ хүргэхдээ, зөв ашиглах замыг анхнаас нь чиглүүлж өгснөөр цаашдын зөв хандлага бий болох давуу талууд гарч болно.

Хүснэгт 1. Фэйсбүүкийн хэрэглээний таамаг цагийг шалгахад

Оролцогч	Фэйсбүүк найзын тоо	Өөрийн баримжаа тоо	Тооцоолсон (цаг/өдөр)
1-р хүн Багш	387	Өдөрт 2 цаг	3,5
2-р хүн Хуульч	4967	Өдөрт 5-6 цаг	9
3-р хүн Багш	72	7 хоногт 1 цаг	0,3
4-р хүн Багш	323	Өдөрт 4-5 цаг	8
5-р хүн МТ	195	Өдөрт 3-4 цаг	5
6-р хүн Багш	155	Өдөрт 1 цаг	1
7-р хүн Багш	615	Өдөрт 2 цаг	3
8-р хүн Эдийн засагч	881	Өдөрт 2 цаг орчим	2
9-р хүн Бизнесмэн	324	Өдөрт 2 цаг орчим	2,8
10-р хүн Эмч	247	7 хоногт 4 цаг	1

IV. Дүгнэлт

Мэдээллийн эринд амьдарч байгаа иргэн мэдээллийг хэдий чинээ хурдан эзэмшинэ, өрсөлдөөнд төдий чиний манлайлагч байх магадлал нэмэгдэнэ. Хэдий тийм ч хэт их мэдээллийн дунд төөрөх, оновчтой арга зам олохгүй байх, мэдээллээ мэдлэг болгож чадахгүй байх г.м бэрхшээл өдөр ирэх тусам нэмэгдсээр байна. Иймээс мэдээллийг зөв сурвалжаас авч, ёс зүйтэй хэрэглэх, түүнийгээ шүүж, мэдлэг, цаашлаад баялаг болгон хувиргах арга замд суралцагчдыг хөтлөх нь багш хүний үүрэгт шинээр нэмэгдэж байна.

Мэдлэг бол хамгийн хурдан хуучирдаг, гэхдээ түгээх тусам үнэ цэнэ нь нэмэгдэж байдаг шавхагдашгүй капитал учир аль болох хурдан түгээхийн тулд бид хамгийн хурдтай техник технологийн боломжийг боловсрол олгох үйлчилгээтэй зөв уяж авч үзэх нь сургалтад илүү их дэвшил, боломжгүй гэж харж байсан үр ашгийг ч авчирч болох юм.

Нүдээ нээхээс эхлээд л технологитой амьдралаа холбосон шинэ зууны иргэдийн боловсрол эзэмшиж байгаа аргаас тэс өөрөөр боловсрол эзэмшсэн багш нар өнөөдөр бүх шатны сургуулийн багш нарын дийлэнх хувийг эзэлж байгаа учир бид өнөөдрийн болон хойчийн шинэ соргог тал, суралцагчийн сонирхолд тулгуурлах, зарчмаа эргэн харах шаардлагыг бий болгож байна. Технологийн ололт амжилтыг зөв ашиглаж, хүн хүч, хөрөнгө, цаг хугацаа зарцуулсан сургалтын платформуудыг байгуулалгүйгээр, гарын

доорх технологийн давуу тал, боломжид тулгуурлан сургалтыг чанартай зохион байгуулж, үр шимийг нь хүртэж болохоор байна.

Дэлхий даяараа нийгмийн сүлжээний асар том давалгаанд орсон, түүнийг хэрэглэхэд өдий төдий сул тал байгаа хэдий ч бид сайн талыг нь олж харж, зөв ашиглаж чадвал бидэнд үр өгөөжөө өгөх боломж байна. Багш нар суралцагчийн Фэйсбүүк сүлжээн дэх хэрэглээг хориглохоос илүүтэй, зөв хэрэглээ рүү нь чиглүүлж өгөх нь өнөөдрийн оюутан - маргаашийн багш нарт суралцагчдаа ойлгох хөшүүрэг болох, тэднийг хяналтгүй, буруу хэрэглээнээс үүдэх олон асуудлыг тойрон гарах чадвартай болгоно гэж харж байна.

Цагийн зүү боломжийг бодит байдал болгохыг бидэнд сануулан, цохилсоор байна.

Цаашдын судалгаа

Энэ ажилд олон нийтийн дунд хэрэглэгдэж байгаа мэдээллийн хэрэгслүүдээс хамгийн олон хэрэглэгчтэй гэдэг шалтгаанаар Фэйсбүүкийг сонгон авсан нь зарим талаар дутагдалтай байж болох юм. Түүнчлэн зөвхөн Фэйсбүүк гэлтгүй суралцагчийн шүүмжлэлт, бүтээлч сэтгэлгээг бууруулах; хэт бэлэнчилж, бүхнийг Интернэтээс олохыг нэн тэргүүнд тавихад хүргэдэг зэрэг технологийн давуу болон сул талуудыг орхигдуулалгүй судлан, оюутнуудын хэрэглээ, санал бодол ямар байгааг авч үзэх нь цаашдын судалгааны зорилт байх болно.

Талархал

Асуулгын судалгааг боловсруулж тусалсан Мэдээлэл зүйн тэнхимийн туслах ажилтан, магистр О.Эрдэнээ болон судалгаанд чин сэтгэлээсээ оролцсон бүх хүмүүст талархал илэрхийлье.

Ашигласан материал

- а. Монгол хэлээр бичигдсэн эх сурвалжууд
2014-2015 оны хичээлийн жилийн Их дээд сургуулийн статистикийн үзүүлэлт, БШУЯ.
Азийн хөгжлийн банк. (2014). ТТ-8241 МОН: Хүртээмжтэй өсөлтийг дэмжих нь судалгааны тайлан.
Дэлхийн Банк. (2010). Монгол улсын дээд боловсрол: Бодлогын баримт бичиг.
Дэлхийн банкны тайлан, “Дээд боловсролыг хөгжүүлэх нь: Зүүн Азийн бүтээмж, өсөлтийг хангахад шаардагдах ур чадвар ба судалгаа шинжилгээ”.
Мөнхтулга.Г. (2014). 3G үйлчилгээ, өнөөгийн байдал... 4G технологи, чиг хандлага.
Цагаан ном-2014, Монгол улсын Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар.
Ч.Долгоржав, Б.Наранбат. (2012). Үүлэн тооцооллыг МУБИС-ийн сургалтын хөтөлбөрт хэрэгжүүлэх асуудалд. Лавай. 9(2013).
- б. Англи хэлээр бичигдсэн эх сурвалжууд
Caroline Lego Muñoz, Terri L. Towner. (2009). How to Use Facebook in the College Classroom.
Frank Alexander Rojas. (2013). Students' Perspective of the Role of Facebook in Their Studies.
Qiyun Wang, Huay Lit Woo, Choon Lang Quek. (2012). Exploring the Affordances of Facebook for Teaching and Learning.
Andrew Trotter. (2007). Federal Study Finds No Edge for Students Using Technology-Based Reading and Math Products.
Cheung, C.M.K., Chiu, P.Y., Lee, M.K.O. (2010). “Online social networks: Why do students use Facebook?”, Computers in Human Behavior, Article in Press.
Christopher Irwin, Lauren Ball and Ben Desbrow, Michael Leveritt. (2012). Students' perceptions of using Facebook as an interactive learning resource at university.
CISCO. (2015). Global Mobile Data Traffic Forecast Update 2014–2019 White Paper.
Facebook Q4 2014 Results.
Global Competitiveness Report (2010-2011), (2011-2012), (2012-2013), (2013-2014), (2014-2015)

- Hew, K.F. (2011). “Students' and teachers' use of Facebook”, Computers in Human Behavior, 27: 662-676.
Mazer, J. P., Murphy, R. E., & Simonds, C. J. (2009). The effects of teacher self-disclosure via Facebook on teacher credibility. Learning, Media and Technology.
Mazman, S. G. & Usluel, Y. K. (2010). Modeling educational usage of Facebook. Computers & Education.
McCarthy, J. (2012). International design collaboration and mentoring for tertiary students through Facebook. Australasian Journal of Educational Technology.
Müge Akyıldız, Metin Argan. Using Online Social Networking: Students' Purposes of Facebook Usage at the University of Turkey.
Nataša Petrović, Dalibor Petrović, Veljko Jeremić, Nemanja Milenković, and Marko Ćirović. Possible educational use of facebook in higher environmental education.
O'Sullivan, P. B., Hunt, S. K., & Lippert, L. R. (2004). Mediated immediacy: A language of affiliation in a technological age. Journal of Language and Social Psychology.
Philip J. Goldstein. (2006). The Future of Higher Education: A View from CHEMA.
Robert B. Kvavik. Convenience, communications, and control: how students use technology, by EDUCAUSE.
Roblyer, M. D., McDaniel, M., Webb, M., Herman, J. & Witty, J. V. (2010). Findings on Facebook in higher education: A comparison of college faculty and student uses and perceptions of social networking sites. The Internet and Higher Education.
Sachs, Wendy (2012). "Facebook Envy: How Cruising Can Kill Self Esteem".
Schwartz, H.L. (2009, September 28). Facebook: The new classroom commons? The Chronicle of Higher Education.
Shane.B. (2011). Teacher Development.
Teclehaيمانot, B., & Hickman, T. (2009). Student-teacher interaction on Facebook: What students find appropriate. In T. Bastiaens et al. (Eds.), Proceedings of world conference on e-learning in corporate, government, healthcare, and higher education.
Universities UK. (2012). Futures for higher education analyzing trends.
<http://www.universitiesuk.ac.uk/highereducation/Documents/2012/FuturesForHigherEducation.pdf>
<http://analytics.socialdaily.com>
<http://Socialbakers.com>
<http://wikipedia.com>
<http://www.cisco.com>
<http://geek.com/news>